



**НИЙСЛЭЛИЙН  
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/283


Улаанбаатар хот

Онцгой комиссын хариуцлагатай  
эргүүл ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4.2, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 188 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 24 дүгээр хурлын шийдвэр, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын 2020 оны "Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/191 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний Их баяр наадмын өдрүүдэд усархаг бороо орох төлөвтэй байгаатай холбогдуулан болзошгүй үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, үүссэн нөхцөл байдлын голомтод шуурхай хүрэлцэн очиж хариу арга хэмжээ авах, мэдээ, мэдээллийг дамжуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Онцгой комиссын ерөнхий эргүүл, хариуцлагатай эргүүлийг 2020 оны 07 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд томилон ажиллуулсугай.
2. Ерөнхий эргүүл, хариуцлагатай эргүүлээр үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний хуваарийг 1 дүгээр, шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Үйл ажиллагаанд шаардагдах 710000 /долоон зуун арван мянга/ төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар /Б.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтэс /М.Цогзолмаа/-т тус тус зөвшөөрсүгэй.
4. Үүрэг гүйцэтгэх үеийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, сахилга хариуцлагыг чанд сахин ажиллахыг ерөнхий эргүүл, хариуцлагатай эргүүлүүдэд үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, батлагдсан хуваарийг мөрдөөгүй албан тушаалтанд холбогдох хариуцлага тооцож ажиллахыг Засаг даргын нэгдүгээр орлогч Г.Батсайханд даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

1170200758


Хан-Уул дүүргийн Засаг даргын  
 2020 оны 07 сарын  
 07-ны өдрийн А.1.28.3  
 захирамжийн 1 дүгээр хавсралт



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ЕРӨНХИЙ  
 ЭРГҮҮЛ, ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛЭЭР ҮҮРЭГ  
 ГҮЙЦЭТГЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХУВААРЬ

№	Огноо	Үүрэг гүйцэтгэх Онцгой комиссын гишүүн		
		Ерөнхий эргүүл	Хариуцлагатай эргүүл	Гүйцэтгэх үүрэг
1.	2020.07.11	Засаг даргын нэгдүгээр орлогч Г.Батсайхан 99110983	Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа В.Батсайхан 80112223	Тухайн өдрийн 09:00 цагаас дараа өдрийн 09:00 цагийн хугацаанд
2.	2020.07.12	Засаг даргын орлогч А.Амартүвшин 99115421	Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Б.Алтантуяа 99013037	24 цагийн үүрэг гүйцэтгэж, болзошгүй үер,
3.	2020.07.13	Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд 99083639	Цэргийн штабын дарга, дэд хурандаа Г.Жаргалсайхан 99005175	усны ослоос урьдчилан сэргийлэх, үүссэн нөхцөл байдлын
4.	2020.07.14	Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар 88114275	Замын цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Хангарьд 93020202	голомтод шуурхай хүрэлцэн очиж хариу арга хэмжээ авах, мэдээ, мэдээллийг
5.	2020.07.15	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Цогзолмаа 99114608	“Хан-Уул зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ-ын захирал Ц.Ган-Эрдэнэ 88114503	дамжуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

Хан-Уул дүүргийн Засаг даргын  
2020 оны 07 сарын 07 өдрийн А/083 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ЕРӨНХИЙ ЭРГҮҮЛ,  
ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хоолны зардал:

№	Өдөрт ажиллах бүрэлдэхүүн	Зардлын утга	Хэмжих нэгж (Хүн өдөр)	Нийт хүний тоо	Нэг бүрийн үнэ (төг)	Нийт өртөг (төг)
1	Ерөнхий хариуцлагатай 2 албан хаагч эргүүл, эргүүлээр	24 цагаар үүрэг гүйцэтгэх албан хаагчийн хоолны зардал	5 хоног	10	15,000	150,000
Бүгд:						150,000

Шатахуун, бичгийн хэрэгслийн зардал:

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн	Нийт хоног	Нийт өртөг
1.	Шатахуун /ээлж тус бүрт/	Литр	40 л (өдөр бүр)	1,400	10	560,000
Бүгд:						560,000
<b>НИЙТ ЗАРДАЛ:</b>						<b>710,000</b>